



Батлав. ШУТИС.МехТС-ийн захирал



Д.ЦОЛМОНБААТАР

"МОНГОЛ ИНЖЕНЕР - 2022" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг. ЗОРИЛГО

Энэхүү үйл ажиллагаа нь оюутан залуус, багш, судлаач, инженерүүдийн мэдлэг, ур чадвар, инженерчлэлийн оновчтой шийдлийг дэмжих, судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх, бизнесийн байгууллага – их, дээд сургуулийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой.

Хоёр. ОНЦЛОГ

Их дээд сургуулиудын оюутнуудын дунд тус тусдаа зохион байгуулагдаж байсан механикийн онолын хичээлийн болон CAD/CAM-ийн олимпиадуудыг нэгтгэн оюутан, багш, судлаач, инженер, техникийн ажилтануудыг хамруулан олимпиад, сургалт, эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн үзэсгэлнэ зэрэг нэгдсэн үйл ажиллагааг 2017 оноос хойш зохион байгуулж байна. Оролцогчдын мэдлэг, ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, сайн туршлагыг харилцан солилцох, санал бодлоо хуваалцах, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үндсэн үйл ажиллагаа чиглэгдэнэ.

Хугацаа: 2022 оны 4-р сарын 22, 23, 24-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

Гурав. ХАМРАХ ХҮРЭЭ

Зохион бүтээх инженерийн тооцоонд механикийн онолын болон зураг, төсөл, тооцоо, үйлдвэрлэлийн загварчлалыг (CAD/CAE/CAM) хэрэглэдэг дотоодын их дээд сургуулийн багш, бакалавр оюутнууд, инженер техникийн ажилтан, судлаач нар.

Дөрөв. ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (2022.04.22, онлайн)
I салбар хуралдаан:
Инженерийн боловсрол дахь технологийн шинэчлэлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв;
II салбар хуралдаан:
Инженерийн салбар дахь загварчлал ба симуляци;
- ТЕХНИКИЙН МЕХАНИКИЙН УЛСЫН ОЛИМПИАД (2022.04.23, онлайн)
- CAD/CAE/CAM-ийн УЛСЫН ОЛИМПИАД (2022.04.23, 24 танхим)

Төслийн сэдэв:

- ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ. Хурлын удирдамж mongol-engineer.mn цахим хуудас дээр тавигдана.

- ТЕХНИКИЙН МЕХАНИКИЙН УЛСЫН ОЛИМПИАД. Сэдэв: “Хөвсгөл нуурт живсэн Сүхбаатар хөлөг онгоцыг татан гаргах ажиллагааны инженерийн шийдэл, тооцоо, технологийн боловсруулалт”. Олимпиадын журам, үндсэн өгөгдөл mongol-engineer.mn, Mongol Engineer facebook дээр тавигдана.
- CAD/CAE/CAM: Олимпиадын журам, жишиг даалгаврууд mongol-engineer.mn, Mongol Engineer facebook дээр тавигдана.

Зохион байгуулагдах газар, хугацаа:

№	Сэдэв	Арга хэмжээний нэр	Хугацаа		Хэлбэр	Зохион байгуулах газар
			Эхлэх	Дуусах		
1	Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг	I салбар хуралдаан Инженерийн боловсрол дахь технологийн шинэчлэлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв	IV.22 Баасан	IV.22 Баасан	Онлайн	-
		II салбар хуралдаан Инженерийн салбар дахь загварчлал ба симуляци				
	Нээлтийн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нээлт	IV.23 Бямба	IV.23 Бямба	Танхим	МехТС, хурлын танхим
2	Улсын олимпиад	Механикийн улсын олимпиад: Багуудын төслийн танилцуулга	IV.23 Бямба	IV.23 Бямба	Онлайн	-
		CAD/CAE/CAM: Ганцаарчилсан болон багийн ур чадварын шалгаруулалт	IV.23 Бямба	IV.24 Ням	Танхим	МехТС, хурлын танхим
	Хаалтын үйл ажиллагаа	Нэгдсэн дүн танилцуулах, шагнал гардуулах үйл ажиллагаа	2022.IV.24 Ням		Танхим	

Эрдэм шинжилгээний хурлын удирдамжыг хавсралт-1, Техникийн механикийн улсын олимпиадын удирдамжыг хавсралт -2, CAD/CAE/CAM улсын олимпиадын удирдамжыг хавсралт -3 тус тус илгээнэ.

Тав. ХАНДИВ, ХУРААМЖ

Шагналын санг зохион байгуулж буй сургууль, оролцогч сургууль, ивээн тэтгэх байгууллага, хувь хүмүүс бүрдүүлнэ.

Хураамжийг МехТС-ийн **Худалдаа хөгжлийн банкны 803-002-2302** тоот дансанд тушаана.

Хүлээн авагчийн нэр: **МЕХАНИК ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ**

Шагнал, урамшуулал:

Оролцсон бүх хүмүүст батламж олгоно.

Эрдэм шинжилгээний хурал (education/engineering)	ИТА, багш
1-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	тус бүр 0.4 сая.төг
2-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	тус бүр 0.3 сая.төг
Шилдэг ханын илтгэл	0.2 сая.төг
Техникийн механикийн олимпиад	Оюутны баг
1-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.5 сая.төг

2-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.4 сая.төг
3-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.3 сая.төг
Удирдагч багш	0.1 сая.төг

CAD/CAE/CAM	Бакалавр оюутан, ИТА
1-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	тус бүр 1 сая.төг
2-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	тус бүр 0.7 сая.төг
3-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	тус бүр 0.5 сая.төг

CAD/CAE/CAM	Багийн тэмцээн
1-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	1 сая.төг
2-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.7 сая.төг
3-р байр - өргөмжлөл, мөнгөн шагнал	0.5 сая.төг

Ерөнхий зохион байгуулагч:



ШУТИС,
*Механик,
тээврийн
сургууль*



**УЛААНБААТАР
ТӨМӨР ЗАМ**
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
НИЙГЭМЛЭГ

*Төмөр замын
дээд
сургууль*



*Металл
боловсруулалт,
инженерчлэлийн
холбоо*



*Үндэсний
батлан
хамгаалахын
их сургууль*



*Хөдөө аж
ахуйн их
сургууль*

Ерөнхий ивээн тэтгэгч байгууллага:

Металл боловсруулалт, инженерчлэлийн холбоо

Дэлгэрэнгүй мэдээллийг:

ШУТИС.МехТС-ийн ЭНБД, доктор (Ph.D) Н.Пүрэвдорж, purevd@must.edu.mn, 94045440,
УБТЗ-ын ТДС-ийн ЭНБД, доктор (Ph.D) М.Бямбасүрэн, byambasuren@rail-inst.mn, 99183426,
МБИХолбооны нарийн бичгийн дарга Г.Энхтуул, g_enkhtuul@must.edu.mn, 89017727,
ШУТИС.МехТС-ийн Техникийн механикийн тэнхимийн эрхлэгч, док (Ph.D) Ш.Цоож,
tsooj@must.edu.mn, 99274776,
ШУТИС.МехТС-ийн Машин үйлдвэрлэлийн салбарын эрхлэгч, док (Ph.D), Г.Оюунбат,
g_oyunbat@must.edu.mn, 99782458,
ШУТИС.МехТС-ийн Техникийн механикийн тэнхимийн багш Ц.Жаргалмаа
jargalmaa_e69@must.edu.mn, 88772020.

Цахим хуудас: mongol-engineer.mn,
Майл хаяг: mongolengineer@must.edu.mn

Face book хаяг: **Mongol Engineer**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, ШУТИС.МехТС, 7-403, 7-214

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
2022.03.11



ШУТИС, Механик,
тээврийн
сургууль



УЛААНБААТАР
ТӨМӨР ЗАМ
хувь нийлүүлсэн
нийгэмлэг

Төмөр замын дээд
сургууль



Үндэсний батлан
хамгаалахын их
сургууль



Хөдөө аж ахуйн
их сургууль



Металл боловсруулалт,
инженерчлэлийн холбоо

“МОНГОЛ ИНЖЕНЕР - 2022” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ТАНИЛЦУУЛГА

Хурлын зорилго:

ШУТИС-ийн МехТС, Төмөр замын дээд сургууль хамтран “Монгол инженер - 2022” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна. Судлаачид харилцан туршлага солилцох, багшлахуйн мэдлэг, чадамж, заах арга зүйн ур чадварыг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдийг олны хүртээл болгоход энэхүү бага хурлын зорилго оршино.

Хугацаа: 2022 оны 04-р сарын 22-ны өдөр зохион байгуулагдана.

1-р хэсэг: Инженерийн салбар дахь загварчлал ба симуляци

- Инженерчлэл, автоматжуулалт, дижитал технологи, тээвэр логистик, метал судлал, метал боловсруулалт, тээврийн салбар дахь инновац, тээврийн салбарын нэгдсэн удирдлага, хяналтын систем, хөдлөх бүрэлдэхүүний болон төмөр замын суурь бүтцийн найдварт ажиллагаа, техникийн оношилгоо, эрчим хүчний хэмнэлт, тээврийн үйлчилгээ

2-р хэсэг: Инженерийн боловсрол

- Инженерийн боловсрол дахь цахим сургалтын асуудлууд, инженерийн боловсролд мэдээлэл харилцааны технологи ашиглах асуудлууд, боловсролын нээлттэй эхийн программ хангамж, платформ, тэдгээрийн боловсруулалт, хөгжүүлэлт, орчин үеийн сургалтын технологийн шинэчлэлийн асуудал, сургалтын дэвшилтэт арга зүй хэрэглэж буй туршлага.

Профессор, багш нарын оролцох чиглэл:

- Онол, практикийн хэлэлцүүлэг/мэдээлэл, туршлага/
- Эрдэм шинжилгээний хурал, постер илтгэл /өгүүлэл/

Зохион байгуулалт:

2020.04.01	Илтгэлийн хураангуй, бүрэн хэмжээний өгүүллэгийг хүлээн авах сүүлийн хугацаа
2020.04.08	Ирүүлсэн материалыг хянаж хариу өгөх /Хянагчийн зүгээс оролцох чиглэл, хэлбэрийг өөрчилж болно/
2020.04.15	Өгүүллийн зассан эцсийн хувилбарыг хүлээн авах
2020.04.18	Хурлын эмхэтгэлийг хэвлэх
2020.04.22	Эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг, хурал, илтгэл шалгаруулах

Материал хүлээн авах:

Өгүүллийг ШУТИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл бичих заавар
https://www.must.edu.mn/mn/esh_oguulel_zaaavar/-ын дагуу бэлтгэж
mongolengineer@must.edu.mn хаягаар ирүүлнэ.



ШУТИС, Механик,
тээврийн
сургууль



УЛААНБААТАР
ТӨМӨР ЗАМ
хувь нийлүүлсэн
нийгэмлэг

Төмөр замын дээд
сургууль



Үндэсний батлан
хамгаалахын их
сургууль



Хөдөө аж ахуйн
их сургууль



Металл боловсруулалт,
инженерчлэлийн холбоо

Дэлгэрэнгүй мэдээллийг:

ШУТИС МехТС

ЭНБД, доктор (Ph.D) Н.Пүрэвдорж purevd@must.edu.mn, 94045440,
ЭШИХариуцсан ажилтан Ю.Ундармаа undarmaa.yu@must.edu.mn, 99030024,
ТМТ-ийн профессор, доктор (Ph.D) Х.Батбаяр batbayarkh@must.edu.mn, 86075099,
ТМТ-ийн багш Ц.Жаргалмаа jargalmaa_e69@must.edu.mn, 88772020.

Төмөр замын дээд сургууль

ЭНБД, доктор (Ph.D) М.Бямбасүрэн byambasuren@rail-inst.mn, 99183426
Вагоны хөтөлбөрийн дэд профессор Ө.Гансүх, Ganna0511@yahoo.com, 99187408

Цахим хуудас: mongol-engineer.mn,
Майл хаяг: mongolengineer@must.edu.mn

Facebook хаяг: **Mongol Engineer**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, ШУТИС.МехТС, 7-403, 7-214

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
2022.03.11



ШУТИС, Механик,
тээврийн
сургууль



УЛААНБААТАР
ТӨМӨР ЗАМ
хувь нийлүүлсэн
нийгэмлэг

Төмөр замын дээд
сургууль



Үндэсний батлан
хамгаалахын их
сургууль



Хөдөө аж ахуйн
их сургууль



Металл боловсруулалт,
инженерчлэлийн
холбоо

"МОНГОЛ ИНЖЕНЕР 2022"

CAD/CAE/CAM-ИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН ТАНИЛЦУУЛГА

Зорилго, ач холбогдол:

Инженерийн зохион бүтээх үйл ажиллагааг хөгжүүлэх, инженерийн төсөл, тооцоонд CAD/CAE/CAM систем, механикийн онолын болон тооцооны загварчлалыг мэргэжлийн түвшинд өргөн хүрээнд хэрэглэх ур чадвартай шилдэг инженер, оюутныг шалгаруулах, инженер, судлаач, багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж байна.

Хамрах хүрээ:

Зохион бүтээх инженерийн төсөл тооцоонд онолын болон программын загварчлал CAD/CAE/CAM системийг өргөн хүрээнд хэрэглэдэг Үйлдвэр аж ахуйн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын инженер техникийн ажилтан, мэргэжилтэн, судлаач оюутан;

Их, дээд сургуулийн бакалавр, магистрын сургалтын хөтөлбөрт CAD/CAE/CAM-ийн хичээлийг судалдаг дотоодын их, дээд сургуулийн багш, оюутнууд тус тус оролцох боломжтой.

CAD/CAE/CAM-ийн улсын олимпадын хүрээнд зохион байгуулах арга хэмжээ:

- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын инженер, техникийн ажилчдын (ИТА) дунд зохиогдох CAD/CAE/CAM-ийн улсын олимпиад;
- Их, дээд сургуулиудын бакалавр, магистр оюутнуудын дунд зохиогдох CAD/CAE/CAM-ийн олимпиад;
- ИТА, оюутны хамтарсан багийн тэмцээн (багийн бүрэлдэхүүнд: 4 хүн).

Оролцогчдод тавигдах шаардлага:

Оролцогчдод насны хязгаарлалт тавихгүй ба тухайн байгууллага, сургууль дээр зохион байгуулагдсан өмнөх шатны шалгаруулалтанд оролцож шалгарсан байна. Баг 4 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Бүртгэл, хураамж:

Үйл ажиллагааны санхүүжилтэнд зориулж оролцох байгууллага, хувь хүмүүс:

- Үйлдвэр аж ахуйн нэгж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг төлөөлөн оролцох баг 500,0 мян.төг;
- Их, дээд сургуулийг төлөөлөн CAD/CAE/CAM-ийн улсын олимпиадад оролцох баг 100,0 мян.төг.
- Хувийн үзүүлэлтээр CAD/CAE/CAM-ийн Улсын олимпиадад оролцогч оюутан 10,0 мян.төг, инженер техникийн ажилтан 50,0 мян.төгрөг.

Зохион байгуулагдах газар, хугацаа:

- Улаанбаатар хот, ШУТИС МехТС,
- 2022 оны 4-р сарын 23, 24.

CAD/CAE/CAM-ийн улсын олимпадыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

МБИХ-н төлөөлөн:

Э.Батбаяр, Г.Энхтуул, С.Арслан, Ц.Чадраабал, Д.Тулга, Ц.Чинзориг

МехТС-ийг төлөөлөн:



ШУТИС, Механик,
тээврийн
сургууль



УЛААНБААТАР
ТӨМӨР ЗАМ
хувь нийлүүлсэн
нийгэмлэг

Төмөр замын дээд
сургууль



Үндэсний батлан
хамгаалахын их
сургууль



Хөдөө аж ахуйн
их сургууль



Металл боловсруулалт,
инженерчлэлийн холбоо

МҮ-ийн салбарын тэнхимийн эрхлэгч Г.Оюунбат, багш С.Батбаатар, З.Баатар, Б.Жавхлан;
Техникийн механикийн тэнхимийн дэд профессор П.Өлзийсайхан

Оюутан болон ИТА нарыг хувийн дүнгээр шалгаруулах даалгаварын задаргаа

№	Даалгаварын төрөл	Үргэлжлэх хугацаа	Оноо	Даалгаварын төрөл
1	1-р хэсэг. Механик инженерийн тооцоо (CAE)	30 мин	20	Өгөгдсөн загварт бат бөхийн тооцоолол хийх даалгавар
2	2-р хэсэг. Үндсэн хэсэг	120 мин	80	Эд ангиудын 3D байгуулалтыг хийж, угсаргааны ажил гүйцэтгэж, ажлын зураг гаргах даалгавар
<i>Жич: 1. Зөөврийн болон суурин компьютерээ оролцогч өөрөө хангаж ирэх ёстой. 2. Харандаа, үзэг балтай ирэх ёстой.</i>				

Багийн тэмцээний даалгаварын задаргаа

№	Даалгаварын төрөл	Үргэлжлэх хугацаа	Оноо	Тайлбар
1	1-р хэсэг. 3D зураг гаргах	120 мин	70	Биет эд ангийн хэмжээг хэмжилт хийн авч 3D байгуулалтыг гүйцэтгэх даалгавар
2	2-р хэсэг. Угсаргаа зураг гаргах	30 мин	30	3D эд ангиудыг програмын орчинд угсрах даалгавар
3	3-р хэсэг. Инженерийн төсөл тооцоо гүйцэтгэх			CAE тооцоог тодорхой эд ангийн хувьд гүйцэтгэх
<i>Жич: 1. Багийн гишүүд өгөгдсөн даалгавар ажлын эд ангиудыг хуваан авч тус бүртээ хэмжилт хийн 3D байгуулалтыг гүйцэтгэнэ. Зурагдсан эд ангиудыг нэгтгэн угсаргааны зургийг гүйцэтгэнэ. Эцэст нь багийн гишүүдээс аль нэг нь тодорхой эд ангийн хувьд CAE тооцоог гүйцэтгэнэ; 2. Багийн тэмцээнд оролцох багууд өөрийн хэмжилтийн багаж, хэрэгслийг хангаж ирнэ; 3. Зөөврийн болон суурин компьютерээ оролцогч өөрөө бэлтгэж ирнэ.</i>				

Дэлгэрэнгүй мэдээллийг:

МБИХ нарийн бичиг Г.Энхтуул, 89017727, g_enkhtuul@must.edu.mn

ШУТИС, Механик, тээврийн сургуулийн багш З.Баатар, 91999188,

baatar.zorigt@must.edu.mn

Цахим хуудас: mongol-engineer.mn,
Майл хаяг: mongolengineer@must.edu.mn

Face book хаяг: [Mongol Engineer](https://www.facebook.com/MongolEngineer)

Металл боловсруулалт, Инженерчлэлийн Холбоо
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө 105, МҮЭСТОрдон, 306 тоот

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
2022.03.11



ШУТИС, Механик,
тээврийн
сургууль



УЛААНБААТАР
ТӨМӨР ЗАМ
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
НИЙГЭМЛЭГ

Төмөр замын дээд
сургууль



Үндэсний батлан
хамгаалахын их
сургууль



Хөдөө аж ахуйн
их сургууль



Металл боловсруулалт,
инженерчлэлийн холбоо

"МОНГОЛ ИНЖЕНЕР - 2022"
ТЕХНИКИЙН МЕХАНИКИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН
ТАНИЛЦУУЛГА

Төслийн сэдэв: “Хөвсгөл нуурт живсэн сүхбаатар хөлөг онгоцыг уснаас гаргах инженерийн шийдэл, тооцоо, технологи боловсруулалт”

сэдвийн хүрээнд усан онгоцыг эрэгт гаргах инженерийн шийдэл, тооцоо, технологийн картын төслийг боловсруулж танилцуулах.

Төсөлд тавигдах үндсэн шаардлага:

Төслийн ажлыг гүйцэтгэхдээ математик, физик суурьтай инженерийн тооцоолол, ялангуяа Техникийн механикийн (Онолын механик, Материалын эсэргүүцэл, Машин механизмын онол, Машины эд анги, Хэрэглээний механик) болон холбогдох мэргэжлийн хичээлүүдээр (эдийн засаг, гидравлик, гидромеханик, машин тоног төхөөрөмж г.м) судалсан онолын тооцоолол, судалгаа, арга аргачлалыг ашигласан байна.

Төслийн ажлыг зөвхөн гар тооцоо, зураглал дээр гүйцэтгэх бус биет загвар дээрх туршилт, загварчлал (CAD/CAE/CAM) зэргийг хэрэглэх замаар дэлгэрүүлж судлах нь давуу тал болно.

Техникийн өгөгдөл:

Төслийн техникийн өгөгдөл дараах бичиг баримтаас бүрдэнэ. Үүнд:

1. Усан онгоцын техникийн бичиг баримт;
2. Газар орны орчны фото зураг, зураглал;
3. Живсэн хөлөг онгоцны усны гүн дэх байрлал, түүнтэй холбоотой хэмжилтийн утгууд;
4. Усны гүний хэмжилтийн утгууд;
5. Холбогдох видео бичлэгүүд;
6. Техникийн өгөгдөлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг багуудад нэгдсэн байдлаар онлайн, танхимаар танилцуулах боломжтой.

Оролцогчдод тавигдах шаардлага:

- Их, дээд сургуулиас оролцож буй баг нь тухайн сургууль дээр зохион байгуулагдсан өмнөх шатны шалгаруулалтанд оролцож шалгарсан байна.
- Сургууль төлөөлөх баг нь 5 бакалавр оюутан, 1 удирдагч багшийн бүрэлдэхүүнтэй байна.

Хугацаа:

- Оролцох багийн мэдүүлгийг **2022.03.31**-ны дотор mongolengineer@must.edu.mn цахим хаягаар хүлээн авна.
- Төслийн техникийн өгөгдлийг **2022.04.01**-ний өдөр www.mongol-engineer.mn цахим хуудсанд байрлуулна.



ШУТИС, Механик,
тээврийн
сургууль



УЛААНБААТАР
ТӨМӨР ЗАМ
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
НИЙГЭМЛЭГ

Төмөр замын дээд
сургууль



Үндэсний батлан
хамгаалахын их
сургууль



Хөдөө аж ахуйн
их сургууль



Металл боловсруулалт,
инженерчлэлийн холбоо

- Төслийн даалгавартай холбоотой зөвөлгөө өгөх сургалтыг **2022.04.10**-ний өдөр ШУТИС, МехТС-ийн 7-407 тоот өрөөнд зохион байгуулна.
- Төслийн үр дүн, тайланг **2022.04.21**-ны дотор mongolengineer@must.edu.mn цахим хаягаар илгээсэн байна.

Төслийн тооцооллын үр дүн, тайланд тавигдах шаардлага:

- Төслийн үр дүн, тайланг бэлтгэхдээ урьдчилсан тараасан template файл (Powerpoint ppt file) дээр бэлтгэнэ.
- Илтгэл нийт Powerpoint-ийн 15 хуудаснаас илүүгүй байна.
- Powerpoint илтгэлтэй хамт үр дүнг тайлбарласан 10 минутын видео бичлэгийг хийж MP4 форматаар хадгалсан байна.
- Powerpoint болон MP4 видео файлыг заасан хугацаанаас өмнө mongolengineer@must.edu.mn руу илгээсэн байна.

Шалгаруулалт:

Багууд төслөө **2022.04.23**-ны өдөр онлайнар ZOOM программ ашиглан комиссд танилцуулна. Шалгуур үзүүлэлт ба үнэлгээг боловсруулах, шилдэг төслийг шалгаруулах ажлыг их, дээд сургуулийн багш нарын төлөөллөөс бүрдэх комисс шийдвэрлэнэ.

Төслийн ажлын дэвшүүлсэн санал, шийдэл, тооцооны дүгнэлт, зөвлөмж нь онол, практикийн ач холбогдолтой; эдийн засгийн бодит судалгаанд суурилсан; үр дүнг үндэслэлтэй тайлбарласан, баталсан, нотолсон г.м инженерийн тооцоолол гүйцэтгэх, хэрэглэх ур чадвараа танилцуулсан хамгийн сайн багийг шалгаруулна.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

ШУТИС, МехТС-ийн Техникийн механикийн тэнхимийн эрхлэгч, док (Ph.D)

Ш.Цоож, tsooj@must.edu.mn, 99274776

ШУТИС, МехТС-ийн Техникийн механикийн тэнхимийн дэд профессор, док (Ph.D)

П.Өлзийсайхан, ulziisaikhan_cdio@must.edu.mn, 99089677

ШУТИС, МехТС-ийн Техникийн механикийн тэнхимийн багш Ц.Жаргалмаа

jargalmaa_e69@must.edu.mn, 88772020.

Цахим хуудас: mongol-engineer.mn,
Майл хаяг: mongolengineer@must.edu.mn

Face book хаяг: **Mongol Engineer**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, ШУТИС.МехТС, 7-403, 7-401

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
2022.03.11